



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах  
өдөр-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/480 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүрэгт “Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсугай.
2. Арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг хоёрдугаар, зарцуулагдах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Баярын арга хэмжээнд зарцуулагдах 2,809,500 (Хоёр сая найман зуун есөн мянга таван зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү) зөвшөөрсүгэй.
4. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хуваарийн дагуу чанартай зохион байгуулахыг Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа) даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.Эрдэнэбаяр С.ЭРДЭНЭБАЯР



AJIL2022 он ажил/захирамж

1123200588

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2022 оны 25 дугаар сарын 18-ны өдрийн  
25 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР-ИЙН  
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн

ахлагч:	Б.Болормаа	Дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Л.Санжийжамц	Засаг даргын Тамгын газрын дарга
	Д.Эрдэнэтуяа	Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга
	Ц.Мягмарсүрэн	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Д.Хүрэлбаатар	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
	Ш.Баасансүрэн	Боловсролын хэлтсийн дарга
	Д.Шүрэн-Эрдэнэ	Мэргэжлийн хяналтын тасгийн улсын байцаагч
	Д.Энхтайван	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
	Х.Ганбат	Эрүүл мэндийн төвийн дарга
	Б.Лхагвасүрэн	Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн дарга, хурандаа
	Г.Тэмүүлэн	Биеийн тамир спортын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Э.Соёмбобат	"Хангай" цогцолбор сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Н.Тунгалаг	44 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч
	С.Отгонтуяа	207 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
	Б.Гэрэлмаа	"Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-ын захирал
	М.Өсөхдэлгэр	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Оюунгэрэл	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга
	Б.Алтанцоож	Соёлын ордоны захирал

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн  
118 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР-ИЙН  
АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Зохион байгуулагдах газар	Төсөв
Угтаж зохион байгуулах ажил					
1	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан зохион байгуулах арга хэмжээний захирамж, төлөвлөгөө гаргах	2022.04 дүгээр сард	ЗДТГ ГБХЗХХ Хороод	БХД	-
2	Сургуульд хамрагддаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчидтай уулзалт зохион байгуулж боловсролын үйлчилгээнд хамруулах	2022.04.12	ЗДТГ Боловсролын хэлтэс ЕБС, СӨБ-ийн удирдлагууд Жайка ОУБ	ЗДТГ-т	0,145
3	Дүүргийн өсвөрийн аварга шалгаруулах волейболын тэмцээн	2022.04.17-04.25	БТСХ Хангай цогцолбор сургууль	БТСХ	1,2
4	“Багахангай марафон-2022” улсын аварга шалгаруулах тэмцээн (Өсвөр үе)	2022.04.30	Ажлын хэсэг	БХД 1-р хороо	1,0
5	“Зөвийг зөвлөө” аянд нэгдэх, арга хэмжээ зохион байгуулах	4-р сард	ИТХ Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс	БХД	-
6	“Би дээрэлхэхгүй” аяныг ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах	4-р сард	Хангай цогцолбор сургууль ГБХЗХХ	БХД	-
7	12-р анги төгсөх сурагчдыг Төрийн ордонтой танилцуулах аялалыг зохион байгуулах	2022.04.23	ГБХЗХХ Хангай цогцолбор сургууль	Төрийн ордон	-
8	СӨБ, ЕБС-ийн хүүхдүүдийг бие	2022.04.25-04.29-ны	БТСХ	БХД	-

	бялдар чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамруулах	өдрийн хооронд	Боловсролын байгууллагууд		
10	“Хүүхдийн баярыг хэрхэн тэмдэглэх вэ” цахим санал асуулгыг хүүхэд багачуудаас авч нэгтгэх	2022.05.10-ны дотор	ГБХЗХХ	ХЦС	
11	ХЭХЗХ, хамтарсан багийн нэгдсэн хэлэлцүүлэг зохион байгуулах	2022.05.13	ГБХЗХХ	ЗДТГ	0.300
12	“ЕБС-ийн өсвөр насны сурагчдад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хор уршгийг ойлгуулах, урьдчилан сэргийлэх” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэхэд туслах “Шинэ алхам” номыг 50 хүүхдэд гардуулах	2022.05.20	ИТХ	ХЦС	
13	Хүүхдүүдийг эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд хамруулах /уралдаанч хүүхдүүд/	2022.05.01-нээс 05.30	Боловсролын байгууллагууд ГБХЗХХ Эрүүл мэндийн төв	ЭМТ-ийн байранд	
14	“Илрүүлэлт” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах	2022.05.30-ны дотор	ГБХЗХХ ЦХ ОБХ	1,2-р хороо	
15	“Smart education 2” төслийн шилдэг бүтээл шалгаруулах уралдаан /6-9 дүгээр ангийн сурагчид/	2022.05.02-ноос 05.25	Боловсролын хэлтэс “Хангай” цогцолбор сургууль Мобиком ХХК	ЗДТГ-ын хурлын заал	
16	“Бяцхан мисс” тэмцээн /3-4, 5-6 нас/	2022.05.25	Соёлын ордон Багахангай тохижилт ОНӨААТҮГ	Соёлын ордон	
17	“Миний баяр” гар зургийн уралдаан /3-6 нас/	2022.05.15-05.30	207-р цэцэрлэг	207 дугаар цэцэрлэгийн байр	
18	“Миний мөрөөдлийн Багахангай” макет хийх уралдаан /6-9 дүгээр анги/	2022.05.25-05.30	БҮТПарк	ЗДТГ-ын 102 тоот	

19	100 буудалт даамны тэмцээн /6-9 дүгээр анги/	2022.05.30-ны өдрийн 14.00 цагт	Ус суваг ашиглалтын товчоо	Ус суваг ашиглалтын товчооны байр	
20	“Хүүхдээ сонсох өдөр” арга хэмжээ зохион байгуулах	2022.05.30	ГБХЗХХ	ХЦС	
21	“Дэлхийн тамхигүй өдөр”-ийг тохиолдуудан “Архи, тамхигүй орчин” өдөрлөг зохион байгуулах	2022.05.31	Эрүүл мэндийн төв Хороод	Төв талбай	
22	Эрүүл мэндийн боловсрол олгох “Дэвжээ” тэмцээн /6-11-р ангийн сурагчид/	2022.05.31	ЭМТ	ХЦС-ийн урлаг заал	
23	“Сэтгэлийн илгээмж” захидлын уралдаан	2022.06.01-ний дотор	ИТХ	1,2-р хороо	
06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулах ажил, арга хэмжээ					
1	Дүүргийн нэгдсэн арга хэмжээ /Нээлт/	2022.06.01	ЗДТГ Ажлын хэсэг		2.8
2	АБТДО өрхийн хүүхэд, хагас, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд гарын бэлэг гардуулах	2022.06.01	ХХҮХ ГБХЗХХ Хороод ААНБ-ууд	Төв талбайд	2,0
3	Дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын нэрэмжит тэмцээн	2022.06.01	Хороод ААНБ-ууд		2,0
4	Флаш моб зохион байгуулах	2022.06.01	ГБХЗХХ	Төв талбайд	-
5	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	2022.06.01	ЖДҮДТ	Төв талбайд	-
6	Тоглоом, худалдаа, хоолны үйлчилгээ зохион байгуулах	2022.06.01	ТХҮХ МХТ Худалдаа үйлчилгээний байгууллагууд	Төв талбайд	-

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2022 оны 25 дугаар сарын 18-ны өдрийн  
2118-дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР-ИЙГ  
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХЭД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Зардлын төрөл		Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Анонс	2.8x9 (2ш)	м <sup>2</sup>	50,4	25,000	1,260,000
3		3,5x2.5 (2ш)	м <sup>2</sup>	17,5	25,000	437,500
4	Шаар		боодол	12	20,000	240,000
5	Уяа		метр	16	7000	112,000
6	Түлш (Нээлтэнд 2-р хорооноос хүүхэд зөөх)		л	50	3200	160,000
7	Хүүхдийн баярын арга хэмжээ зохион байгуулах талбай ариутгал		м2	1920	3125	600.000
Нийт дүн:						2,809,500